



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 01 сарын 02 өдөр

Дугаар А/01

Нарийнтээл сум

Сарчилсан төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43, 46 дугаар зүйл, Төсвийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1.6 дахь заалт, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн “Сумын 2026 оны төсөв батлах тухай” 09/02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын орон нутгийн орлогыг 1 дүгээр хавсралтаар, Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төсвийн сарчилсан хуваарийг 2 дугаар хавсралтаар, Засаг даргын Тамгын газрын төсвийн сарчилсан хуваарийг 3 дугаар хавсралтаар, багуудын төсвийн сарчилсан хуваарийг 4 дугаар хавсралтаар, Ерөнхий боловсролын сургууль, Сургуулийн өмнөх боловсролын байгууллага, Эрүүл мэндийн төв, Баянтээг багийн бага сургууль, Сургуулийн өмнөх боловсролын байгууллага, Эрүүл мэндийн төв, Соёлын төв зэрэг байгууллагуудын тогтмол зардал болон гэрээт ажилчдын цалинг 5 дугаар хавсралтаар, Хоршоо хөгжүүлэх сангийн зарцуулалтын хуваарийг 6 дугаар хавсралтаар, Эрсдэлээс хамгаалах сангийн сарчилсан хуваарийг 7 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Дээрх байгууллагуудын төсвийг батлагдсан төсөвт багтаан сарчилсан хуваарийн дагуу зарцуулж байгаад хяналт тавьж ажиллахыг санхүү албаны дарга бөгөөд төсвийн ерөнхий нягтлан бодогч (Г.Наранхүү)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.ЦОГТБААТАР



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 01 сарын 05 өдөр

Дугаар А/03

Нарийнтээл сум

Цэргийн бүртгэл явуулах ажлын хэсэг
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43, 46 дугаар зүйл, Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4, Цэргийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4, 34.1, аймгийн Засаг даргын 2026 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн "Цэргийн бүртгэл явуулах тухай" А/02 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2026 оны цэргийн бүртгэлийг явуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Ичинноров (Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүд: Ч.Оюунзул (Архив, бичиг хэргийн ажилтан)

Н.Мягмаржав (Газрын даамал)

Б.Цогтдэлгэр (Баянтээг багийн зохион байгуулагч)

Ц.Ганхуяг (1 дүгээр багийн Засаг дарга)

Б.Базарсад (2 дугаар багийн Засаг дарга)

П.Төмөртоогоо (3 дугаар багийн Засаг дарга)

А.Энхбаатар (4 дүгээр багийн Засаг дарга)

Д.Ангирмаа (Насан туршийн суралцахуйн нэгжийн
багш)

2.Цэргийн бүртгэлийг Шарга, Баянтээг, Өндөрхөмөг, Цагаан-Овоо багууд 2026 оны 01 дүгээр сарын 05-ны өдрөөс 19-ны өдөр хүртэлх хугацаанд явуулсугай.

3.Багийн Засаг дарга нарт ээлжит цэргийн бүртгэлийн бэлтгэлийг хангаж, 18-65 насны I,II дүгээр зэргийн бэлтгэл үүрэгтэн эрчүүд, тусгай мэргэжлийн эмэгтэйчүүдийн судалгааг бэлэн болгож бүрэн хамруулахыг үүрэг болгосугай.

4.Цэргийн бүртгэлийг чанартай, үнэн зөв явуулж, дүн мэдээг хугацаанд нь аймгийн Цэргийн штабт хүргэхийг ажлын хэсгийн ахлагч (Б.Ичинноров)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.ЦОГТБААТАР

622611005



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 01 сарын 08 өдөр

Дугаар А/04

Нарийнтээл сум

“Албан тушаалын тодорхойлолт батлах тухай”

Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5, Захиргааны ерөнхий хуулийн 43, 46 дугаар зүйл, Монгол Улсын Эрүүл мэндийн сайдын 2025 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн “Албан тушаалын үлгэрчилсэн тодорхойлолт батлах тухай” А/371 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын Эрүүл мэндийн төвийн эрхлэгч их эмчийн албан тушаалын тодорхойлолтыг хавсралтаар баталсугай.

2.Батлагдсан албан тушаалын тодорхойлолтыг 2026 оны 01 дүгээр сарын 08-ний өдрөөс эхлэн мөрдөж үр дүнг хариуцан ажиллахыг Эрүүл мэндийн төвийн эрхлэгч их эмчид үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.ЦОГТБААТАР



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 01 сарын 08 өдөр

Дугаар А105

Нарийнтээл сум

“Захирамжийн зарим хэсгийг өөрчлөх тухай”

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43, 46 дугаар зүйл, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1, 14 дүгээр зүйлийн 14.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Газрын кадастрын мэдээллийн санг солбицлын нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх ажлын хүрээнд газрын кадастрын мэдээллийн сангийн өгөгдлийг засварлах, геодезийн солбилцол, өндөр, тусгагийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх, турших, нэгж талбарын хувийн хэргийг шинэчлэн бүрдүүлэх” ажил хэрэгжсэнтэй холбогдуулан хавсралтад дурдагдсаны дагуу 1 иргэний өмчилсөн газрын мэдээллийг өөрчилсүгэй.

2.Захирамж гарсантай холбогдуулан Засаг даргын 2008 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 39 дүгээр захирамжийн хорин зургаад байгаа 1 иргэний холбогдох хэсгийг хүчингүйд тооцсугай.

3.Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд өмчлөх эрхээ хэрэгжүүлэхийг газар өмчлөгчдөд, иргэний өмчилсөн газрын хил заагийг газар дээр нь тэмдэгжүүлж, хүлээлгэн өгөх, газрын улсын бүртгэлд бүртгэх ажлыг зохион байгуулж, газар өмчлөгчийг хуулийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлэхэд хяналт тавьж ажиллахыг Газрын даамал (Н.Мягмаржав)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.ЦОГТБААТАР



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 01 сарын 16 өдөр

Дугаар А/06

Нарийнтээл сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.3 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 43, 46 дугаар зүйл, Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн "Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай" 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Сумын төвийн хогийн менежмент"-ийг хэрэгжүүлэх бүлгийг шалгаруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: А.Энхбаатар (Цагаан-Овоо 4 дүгээр багийн Засаг дарга)

Гишүүд: Н.Мягмаржав (Газрын даамал)
С.Амаржаргал (Жижиг дунд үйлдвэрлэл, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн)
Г.Гантогтох (Иргэний төлөөлөл)

Нарийн бичгийн дарга: Ц.Гаваа (Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн)

2.Дээрх ажлыг шалгаруулахдаа худалдан авах ажиллагааны хууль, журмыг мөрдөн ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (А.Энхбаатар)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



С.ЦОГТБААТАР



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 01 сарын 16 өдөр

Дугаар А/07

Нарийнтээл сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.3 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 43, 46 дугаар зүйл, Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн "Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай" 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Баянтээг багийн хогийн менежмент"-ийг хэрэгжүүлэх бүлгийг шалгаруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Базарсад (Баянтээг 2 дугаар багийн Засаг дарга)

Гишүүд: Н.Нямсүрэн (Нийгмийн даатгалын байцаагч,
мэргэжилтэн)

Б.Цогтдэлгэр (Баянтээг багийн зохион байгуулагч)

Д.Бадамцэцэг (Иргэний төлөөлөл)

Нарийн бичгийн дарга: Ж.Адъяадорж (Байгаль хамгаалагч)

2. Дээрх ажлыг шалгаруулахдаа худалдан авах ажиллагааны хууль, журмыг мөрдөн ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Базарсад)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



С.ЦОГТБАААТАР



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 01 сарын 28 өдөр

Дугаар А/08

Нарийнтээл сум

Тендерийн гүйцэтгэгчийг сонгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1, 48 дүгээр зүйлийн 48.2.4, 48.2.6, Захиргааны ерөнхий хуулийн 43, 46 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Сумын төвийн хогийн менежмент"-ийн ажлыг шалгаруулах ажлын хэсгийн 2026 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 01 дүгээр зөвлөмжийн дагуу орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжих "Сумын төвийн хогийн менежмент"-ийг хэрэгжүүлэх ажлын тендерийг 19,008,000 (арван есөн сая найман мянган) төгрөгөөр "Эвийн хүч" бүлгээр гүйцэтгүүлэхийг зөвшөөрсүгэй.

2."Сумын төвийн хогийн менежмент"-ийн ажлыг гүйцэтгэх "Эвийн хүч" бүлэгтэй гэрээ байгуулж, ажлын явцад хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Ичинноров)-д даалгасугай.

3.Гэрээнд заасан хуваарь, ажлын гүйцэтгэлийн дагуу санхүүжилт олгохыг нягтлан бодогч (Ц.Сувд-Эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



С.ЦОГТБААТАР



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 01 сарын 28 өдөр

Дугаар А/09

Нарийнтээл сум

Тендерийн гүйцэтгэгчийг сонгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1, 48 дүгээр зүйлийн 48.2.4, 48.2.6, Захиргааны ерөнхий хуулийн 43, 46 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Баянтээг багт хогийн менежмент"-ийн ажлыг шалгаруулах ажлын хэсгийн 2026 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 01 дүгээр зөвлөмжийн дагуу орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжих "Баянтээг багт хогийн менежмент"-ийн хэрэгжүүлэх ажлын тендерийг 15,840,000 (арван таван сая найман зуун дөчин мянган) төгрөгөөр "Хамтын хүч" нөхөрлөлөөр гүйцэтгүүлэхийг зөвшөөрсүгэй.

2."Баянтээг багт хогийн менежмент"-ийн ажлыг гүйцэтгэх "Хамтын хүч" бүлэгтэй гэрээ байгуулж, ажлын явцад хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Ичинноров)-д даалгасугай.

3.Гэрээнд заасан хуваарь, ажлын гүйцэтгэлийн дагуу санхүүжилт олгохыг нягтлан бодогч (Ц.Сувд-Эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



С.ЦОГТБААТАР



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 01 сарын 29 өдөр

Дугаар А/10

Нарийнтээл сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээний
хугацааг сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43, 46 дугаар зүйл, Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 37 дугаар зүйлийн 37.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацаа нь дууссан иргэдийн хүсэлтийг харгалзан 15 нэгж талбарын газрын газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг хавсралтад заасан хугацаагаар сунгасугай.

2. Газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацаа нь сунгагдсан иргэнтэй холбогдох хууль тогтоомжийн дагуу газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгон, газрын улсын бүртгэлд бүртгэхийг газрын даамал (Н.Мягмаржав)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.ЦОГТБААТАР



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 01 сарын 29 өдөр

Дугаар А/11

Нарийнтээл сум

Тамхины зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43, 46 дугаар зүйл, Зөвшөөрлийг тухай хуулийн 5.3 дугаар зүйлийн 5.3.1, Тамхины хяналтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, 7.9, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тамхи худалдаалах, түүгээр үйлчлэх аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тавигдах шаардлагыг хангасан "Анги-2" хүнсний дэлгүүрт 2 жилийн хугацаатай тамхины зөвшөөрөл олгосугай.

2.Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгосон "Анги-2" хүнсний дэлгүүрт яналт тавьж ажиллахыг Хууль, эрх зүй, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн (С.Баасандулам), Хэсгийн төлөөлөгч, цагдаагийн ахлах дэслэгч (У.Мягмарнасан) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.ЦОГТБААТАР



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 01 сарын 29 өдөр

Дугаар А/12

Нарийнтээл сум

Газар эзэмшүүлэх эрхийн гэрчилгээг бусдад
шилжүүлэх тухай

Монгол Улсын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43, 46 дугаар зүйлийн, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4, 38.6 дахь хэсэг, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн ерөнхий газрын даргын 2025 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн А/121 дугаар тушаалаар батлагдсан "Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам"-ын 5.4 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Өндөрхөмөг 3-р багт байрлах 4 нэгж талбарыг эзэмшигчдийн хүсэлтийн дагуу газар эзэмших эрхийг хавсралтаар шилжүүлсүгэй.

2.Дээрх газар эзэмших эрхэд гарсан өөрчлөлтийг газрын улсын бүртгэлд бүртгэж, гэрээг зохих журмын дагуу байгуулан, гэрчилгээ олгохыг газрын даамал (Н.Мягмаржав)-т үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Засаг даргын 2013 оны 07 дугаар сарын 31-ны өдрийн "Газар эзэмшүүлэх тухай" А/107 дугаар захирамжийн хавсралтын С.Дуламдоржийн холбогдох хэсэг, 2016 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн "Газар эзэмшүүлэх тухай" А/18 дугаар захирамжийн хавсралтын Т.Батбаатарын холбогдох хэсэг, 2016 оны 03 дугаар сарын 21-ны өдрийн "Газар эзэмшүүлэх тухай" А/34 дүгээр захирамжийн хавсралтын 8 дугаар дэсд байгаа Д.Дэгдмаагийн холбогдох хэсэг, 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн "Газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацаа сунгах тухай" А/218 дугаар захирамжийн М.Гантөмөрийн холбогдох хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай

ЗАСАГ ДАРГА



С.ЦОГТБААТАР



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 01 сарын 29 өдөр

Дугаар А/13

Нарийнтээл сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43, 46 дугаар зүйл, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 31.1.3 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн "Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай" 02 дугаар тогтоолын хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Сумын төв болон Баянтээг багийн төвд хот, тосгон, бусад суурин газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа" хийх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг дараах бүрэлдхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Н.Нямсүрэн (Нийгмийн даатгалын байцаагч)

Гишүүд:

П.Төмөртоогоо (Өндөрхөмөг 3 дугаар багийн Засаг

дарга)

Б.Ган-Өлзий (Хүүхэд гэр бүлийн нийгмийн ажилтан)

Ч.Оюунзул (Архив, бичиг хэргийн ажилтан)

Нарийн бичгийн дарга: Н.Мягмаржав (Газрын даамал)

2.Дээрх ажлыг гүйцэтгэхдээ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг мөрдөн ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Н.Нямсүрэн)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



С.ЦОГТБААТАР



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 01 сарын 29 өдөр

Дугаар А/14

Нарийнтээл сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43, 46 дугаар зүйл, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 31.1.3 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн "Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай" 02 дугаар тогтоолын хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын газар зүйн нэрийн тодруулалт мэдээллийн сан бүрдүүлэх" ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг дараах бүрэлдхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Г.Наранбаатар (Бэлчээр, газар тариалан хариуцсан мэргэжилтэн)

Гишүүд: Н.Нямсүрэн (Нийгмийн даатгалын байцаагч)
Ц.Гаваа (Төсөв, төрийн сангийн мэргэжилтнийг түр орлон гүйцэтгэгч)
О.Цэрэннадмид (ИТХ-ын төлөөлөгч)

Нарийн бичгийн дарга: Н.Мягмаржав (Газрын даамал)

2.Дээрх ажлыг гүйцэтгэхдээ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг мөрдөн ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Г.Наранбаатар)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



С.ЦОГТБААТАР



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 01 сарын 29 өдөр

Дугаар А/15

Нарийнтээл сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43, 46 дугаар зүйл, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 31.1.3 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн "Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай" 02 дугаар тогтоолын хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Сумын нутаг дэвсгэрт палентлоги, архилогийн судалгааг хийх" ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг дараах бүрэлдхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Шинэбаатар (Мал аж ахуй асуудал хариуцсан мэргэжилтэн)

Гишүүд: А.Лхагвадолгор Улсын бүртгэгч
С.Амаржаргал (Жижиг дунд үйлдвэрлэл, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн)
Ч.Оюунзул (Архив, бичиг хэргийн ажилтан)

Нарийн бичгийн дарга: Н.Мягмаржав (Газрын даамал)

2.Дээрх ажлыг гүйцэтгэхдээ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг мөрдөн ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Шинэбаатар)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



С.ЦОГТБААТАР



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 01 сарын 29 өдөр

Дугаар А/16

Нарийнтээл сум

Г 2025 оны сумын тэргүүнүүд шалгаруулах Г
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43.1, 46.1 дүгээр зүйл, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар 27-ны өдрийн "Сумын 2026 оны төсөв батлах тухай" 09/02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2025 оны сумын Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх зорилтуудыг ханган биелүүлж тухайн салбарт эрхэлсэн ажилдаа хөдөлмөрийн амжилт гаргасан 1 дүгээр багийн малчин Ш.Доржгочоо, эхнэр Д.Баасандулам, 1 дүгээр багийн малчин Н.Наранбаатар, эхнэр Б.Бямбадолгор, 1 дүгээр багийн малчин Д.Энхтөвшин, эхнэр Э.Оюунбилэг, 2 дугаар багийн малчин Д.Лхамхүү, эхнэр Г.Сэнгэмаа, 2 дугаар багийн малчин С.Дарьсүрэн, 2 дугаар багийн малчин Ц.Сэр-Од, эхнэр Д.Эрдэнэсүрэн 3 дугаар багийн малчин А.Урангуа, 3 дугаар багийн малчин Ө.Төмөрбаатар, эхнэр Ө.Нямлхам, 4 дүгээр багийн малчин Г.Сосорбурам, эхнэр А.Янжинсүрэн, 4 дүгээр багийн малчин Д.Амартүвшин, эхнэр Б.Долгорсүрэн, 4 дүгээр багийн малчин Ц.Ивгээл, эхнэр Ш.Энхжаргал, 4 дүгээр багийн малчин А.Найдан, эхнэр Ц.Долгордулам, нарыг "Сумын аварга малчин"-аар,

1 дүгээр багийн малчин Г.Ууганбаяр, эхнэр М.Норов-Эрдэнэ, 2 дугаар багийн малчин Д.Амартүвшин, эхнэр Д.Тогообат, 2 дугаар багийн малчин Ж.Эрдэнэсүрэн, эхнэр Ч.Баасандолгор, 4 дүгээр багийн малчин Б.Сугарсанчир, эхнэр А.Гэрэлцэцэг нарыг "Сумын Мянгат малчин"-аар

3 дугаар багийн малчин Г.Энхбаяр, эхнэр Б.Пүрэвсүрэн 4 дүгээр багийн малчин Г.Ганзориг, эхнэр Д.Наранмандах нарыг "Сумын аварга үхэрчин"-ээр

1 дүгээр багийн малчин Д.Загаррагчаа, эхнэр М.Зээмаа, 2 дугаар багийн малчин Ж.Мягмардорж, эхнэр Б.Гэрэлчимэд, 3 дугаар багийн малчин А.Түвшинжаргал 4 дүгээр багийн малчин Б.Доржзовд, эхнэр Н.Цэрэндолгор нарыг сумын "Шилдэг залуу малчин"-аар,

1 дүгээр багийн уяач Д.Найгалсүрэн, 1 дүгээр багийн уяач Л.Гантөмөр 2 дугаар багийн уяач Б.Нархажид, 3 дугаар багийн уяач Д.Батдолгор нарыг "Сумын алдарт уяач"-аар

Сумын Засаг даргын Тамгын газрын Бэлчээр, газар тариалан хариуцсан мэргэжилтэн Г.Наранбаатарыг "Сумын Төрийн захиргааны Тэргүүний ажилтан"-аар,

Эрүүл мэндийн төвийн сувилагч С.Пүрэвсүрэнг "Эрүүл мэндийн тэргүүний ажилтан"-аар,

Ерөнхий боловсролын сургуулийн дунд ангийн сургалтын менежер Р.Сарантуяаг "Сумын Боловсролын тэргүүний ажилтан"-аар,

Баянтээг ХК-ний дугуйт ачигчийн операторчин Ж.Батжаргалыг "Сумын уул уурхайн тэргүүний ажилтан"-аар

"Эх нутгийн буян ХХК"-ний машинист Ч.Бямбадорийг "Сумын эрчим хүчний тэргүүний ажилтан"-аар

ЕБСургуулийн жижүүр Б.Төмөрбаатарыг "Сумын төрийн үйлчилгээний тэргүүний ажилтан"-аар

"Түмэн арвайн түрүү" ХХК-ны худалдагч Б.Батдолгор "Сумын үйлчилгээний тэргүүний ажилтан"-аар

Хувиараа хөдөлмөр эрхлэгч С.Отгонсүрэнг "Сумын үйлдвэрлэлийн тэргүүний ажилтан"-аар

"Монгол Улсын Боловсролын Их" сургуулийн оюутан Г.Төмөр-Очирыг "Сумын тэргүүний оюутан"-аар

Ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар ангийн сурагч О.Түвшинбаярыг "Сумын Тэргүүний сурагч"-аар тус тус шалгаруулсугай.

2.Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийн хөгжлийн зорилтуудыг ханган биелүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулж, өөрийн салбартаа хамт олноо манлайлан ажилласан Г.Бат-Эрдэнэ, Ш.Лхгавасүрэн, Г.Оргилболд, Д.Наранбаатар, А.Пүрэвдавга нарыг "Сумын Засаг даргын баярын бичиг"-ээр тус тус шагнасугай.

ЗАСАГ ДАРГА



С.ЦОГТБААТАР